

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
ТАЙЛАН

2022 оны 09 дугаар сарын 29

Улаанбаатар хот

2022 оны гуравдугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дугаар сарын 29-ний өдрийг дуустал нийт 48 өргөдөл, хүсэлт ирж хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн. Үүнээс тайлант хугацаанд буюу 2022 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 21 өргөдөл хүсэлт ирж хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн.

2022 оны гуравдугаар улирлын өргөдөл гомдлын дэлгэрэнгүй тайлангийн хувьд авч үзвэл:

Хугацаандаа шийдвэрлэсэн - 21, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 0, судалж байгаа 0 үзүүлэлттэй байна.

Үүнээс:

1. Гомдол – 2
2. Санал-0
3. Хүсэлт – 20

Өргөдөл гомдлын тайлангийн хувьд авч үзвэл:

| № | Ангилал | Өргөдөл, гомдлын тоо |
|---------------------------|-------------------------------------|----------------------|
| 1 | Ажлаас чөлөөлөгдөх тухай | 8 |
| 2 | Цалинтай чөлөө хүсэх тухай | 3 |
| 3 | Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай | 4 |
| 4 | Ээлжийн амралтын урамшууллын талаар | 1 |
| 5 | Байгууллагад үлдэн ажиллах хүсэлт | 1 |
| 6 | Жирэмсний амралт авах талаар | 1 |
| 7 | Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тухай | 1 |
| 8 | Ажилд орох тухай | 1 |
| 9 | Гомдол | 2 |
| Нийт өргөдөл, гомдлын дүн | | 21 |

Гомдол шийдвэрлэсэн тухай:

2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд иргэн Ц.Рэнцэнхандаас гаргасан гомдлыг хүлээн авч иргэнд хариуг 9918-5069 дугаарын утсаар өгч ажилласан.

Өргөдөл гомдлын зөрчлийн хувьд:

Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг өдөрт нь хүлээн аваагүй гэх 2 зөрчил бүртгэгдсэн байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлангийн хувьд авч үзвэл:

2022 оны хагас жилийн байдлаар байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 9 цаг 12 минут байсан бол 2022 оны гуравдугаар улирлын байдлаар 22 цаг 50 минут болж ахиц гарсан байна. 2022 оны 06 дугаар сарын 15-ны “Чиглэл хүргүүлэх тухай” Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирсэн 03/3138 дугаартай бичгийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны хагас жилийн өргөдөл, гомдлын тайлант мэдээг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг

даргын Тамгын газар болон Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв зэрэгт хүргүүлсэн, дүн шинжилгээ хийсэн дэлгэрэнгүй мэдээллийг ub-procurement.mn веб сайтад байршуулан мэдээллэж байна.

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭНХТАЙВАН

ХЯНАСАН:
ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.АНАР

ТАЙЛАН ГАРГАСАН :
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТНИЙ АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОРХОНТУУЛ

